

**ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 12 ДУГААР СУРГУУЛИЙН
11 ДҮГЭЭР АНГИЙН СУРАГЧДААС АВАХ МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН АНХИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН
МАТЕРИАЛ**

ЗАХИРАЛ БАТЛАВ М.АЮУШХОРЛОО

2024.06.06

Хугацаа 80 минут

А хувилбар

Хэрлэн сум

Нийт оноо: 40

Анги:

Сурагчийн нэр:

Эхийг анхааралтай уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.

Хунгийн чуулган

... Хунгийн чуулганд зорьж очдоггүй гэх хэн хэзээ зохиосон нь мэдэгдэхгүй иш мухаргүй үг ирж буцаад л байв. Гэвч тэгэх тусам очмоор бодогдож намар намарт байж суухын аргагүй болно. Тийшээ аваад яваач гэж бараг амьтан болгоноос гуйж байж сая нэг алтан боломж ирдэг юм байна. Өглөө Улаанбаатарт тууж явсан хүн үдэш нь Баруун-Уртын төв талбай дээр зогсож байлаа. Эндээ хоноод маргааш өглөө нь эртлэн Дарьганга явах болж, аймгийн захиргааны нэгдүгээр давхарт байх зочид буудалд хоног төөрүүлэхээр орлоо. ... Хөл хөдөлгөөн эхлэнгүүт Сүхбаатар аймагт суудаг цорын ганц танил болох Ай.Төмөр-Очир ахыг асууж сурлаа. ... Төдөлгүй бид хэл үг авалцлаа. Мань хүн ч давхиад ирэв. Бид төрийн төв хэвлэлд нэг тогоон дотор буцалж явсан улсын хувьд ах дүү хоёр шиг тэврэлдэн уулзлаа. Би ч зорьж ирсэн хэрэг явдлаа дуулгав, ах хүү ч тусалж дэмжихээр тогтов. Ингээд төрийн сайдын машинаас Төмөр-Очирын ногоон тэрэг рүү шилжиж суугаад Дарьгангын зүг хөдөлдөг юм байна. Түүнтэй ингэж ханьсах дотоод хүсэл надад байв. Ай.Төмөр-Очир миний зорин зорин ирж байгаа хунгийн чуулганы талаар анх төрийн төв хэвлэлд бичсэн сэтгүүлч. Тийм болохоор түүнээс асууж сурах юм их байв. ... Ай ах замдаа ам хуурайгүй. Улс төр, уран бүтээл гээд явж өгөв. Тийн хуучилсаар үдшийн бүрийгээр Дарьгангад ирж Холбоо нуур руу шууд хөдөллөө. Тэнгэрт түг түмэн од гялбалзаж, нуурын уснаа мянган цагаан хун гэрэлтэн хөвсөн газрын диваажинд хүрч очжээ. Нүд унагахгүй байхын аргагүй бургастай төгөл... Төгөл дотор даарсан чандага шиг гурван цагаан гэр. Багийн даргынх, бага эмчийнх, нөгөө нь харин буурчийн гэр.

... Үүр цавцайн гийж, талын өглөө яах ийхийн зуургүй ургаад ирэв. Босоод айлын шар нохойгоор хань хийж аваад нуурын эрэг рүү алхчихлаа. Холбоо нуур, хунгийн чуулган хоёр бие биенийхээ сүрийг дарж ядан мэлтэлээж байна. Захаасаа зайрмагтаж хөлдсөн нуур хунгаа гол руугаа шахан багтааж ядаж байх шиг. Лав мянган хун бий гэсэн үнэн бололтой. Гэхдээ шувууг хонь шиг тоолж болдоггүй юм байна. Өдөн цагаан хун сүрэг сүргээрээ сүжрэн бүлэрч байснаа усны мандлыг далавчаараа пад пад хийтэл алгадан хөөрч, нуураа хэдэнтэй хошууран тойрсноо эргэн хурган бууна. Зарим нь жигтэйхэн зожирч хоёулхнаа хүзүү сээрээ орооцолдуулан эрхлэлдэж, уран цагаан далавчаа шүхэр шиг дэлгэн өөд өөдөөсөө ус цацалж тоглоно. Энд нэгэн хос тийнхүү янаглан байхад тэр захад зарим нь хурал хуй болон сүржигнэж бөөгнөрөлдөн хашгиралдана. Тэгж тэгж хэсэг хэсгээрээ чимээгүйхэн арилж өгдөг гэнэ. Хун ирэх нь ерөөсөө мэдэгддэггүй атлаа явах нь орчлонг тэр аяар нь үймүүлж орхидог бололтой. ... Ямбархуу, ялархуу шувуу юм уу даа. Харахад нэг л их хээнцэр ганган амьтан. Дуулалдаад л, бүжиглээд л, эрхлээд л, хөдөлж ядаад л... Амьтны ертөнц бас л хүний хорвоо шиг өнгөний хорвоо аж.

... Ахиад л би нуурын эрэгт сууж байна. Энэ удаа Төмөр-Очир ахтайгаа хүүрнэж суув. "... Хунгийн чуулган бол Алтан овоо, Шилийн богд шиг манай Дарьгангын гайхамшгуудын нэг юм. Хун шувуу мянга мянгаараа ирэн дуулж чуулдаг энэ үеийг би юутай ч зүйрлэшгүй амраг улирал гэж боддог. Их ухаарлын, уянга дууллын цаг юм. Урд шөнө энд бид чагнаж хонолоо. Хүний хорвоогийн зовлон жаргалыг яриад ч байх шиг, сэтгэл үелзмээр айхтар орчин байдаг юм байна. Холоос зорьж ирсэн чамд бол уран бүтээлийн онгод хүчийг хайрлах байх. Хунгийн чуулганы тухай сайн нийтлэл, сайн бүтээл туурвигдаагүй байгаа шүү. ... Аливаа юм хоёр талтай. Нэг талаар аялал жуулчлал хөгжих таатай түшиц газар мөн ч нөгөө талаар түүнийхээ хэрээр гадна дотныхны хөлд онгон байгаль талхлагдаж байна. Алтан овоонд мөргөж, Шилийн богд дээр гарсан хүн өдийд хунгийн чуулган үзэхгүй яаж буцахав. Бүгд л ирж байна. Гэхдээ яг хунгийн чуулган үзнэ гэж мянган бээрийг туулан ирж байгаа гэх нь надад хувьдаа таатай санагддаггүй л юм. Уран бүтээлч та нарт бол өөр л байдаг биз. Гэхдээ... Хун бол бас хатуу шувуу шүү дээ" гэв.

... Ах бид хоёрын яриа ийнхүү өндөрлөв. Бодол хөвөрнө. Үнэхээр хачин сониноор дүүрэн хорвоо юм даа. Хун ганцаархнаа цасан цагаанаараа, ганцаархнаа ариунаараа үлдсэн гэдэг үнэхээр үнэн байх...

Нийлмэл өгүүлбэр:

.....
.....

Нийлмэл өгүүлбэрийн бүтэц, хэв шинж:

Холбогдсон арга нь:

2. Дээрх эхээс мэдрэмж, сэтгэгдэл илэрхийлсэн үг хэллэг нэг, таамагласан утгатай баймж үг нэгийг тус тус олж бичээд, утга ойролцоо үг, хэллэгээр солин найруулж бичээрэй. / 4 оноо /
Мэдрэмж, сэтгэгдэл илэрхийлсэн үг хэллэг:

Солин найруулсан нь:

Таамагласан утгатай баймж үг:

Солин найруулсан нь:

3. А. "Тэнгэрт түг түмэн од гялбалзаж, нуурын уснаа мянган цагаан хун гэрэлтэн хөөсөн газрын диваажинд хүрч очжээ." өгүүлбэрт буй тодруулсан бүтээврийн утга, үүргийг зөв тодорхойлж бичээрэй. /2 оноо/

нуурын

гялбалзаж

- Б. ... нуурын уснаа мянган цагаан хун гэрэлтэн" тодруулсан бүтээврийг ойролцоо утгатай бүтээврээр солин найруулж бичээрэй. / 2 оноо /

Солин найруулсан нь:

4. Дараах үгийг холбож бичээд, зөв бичих дүрмийг тайлбарлаарай. / 2 оноо /
мэлтэлз+ я, е, ё =

Дүрэм нь:

5. "хориг" хэмээх үгийн зөв бичих дүрмийг тайлбарлаад, уг дүрэмд холбогдох үг нэгийг бичээрэй./2 оноо/

Дүрэм:

Жишээ үг:

6. Уран зохиолын хичээлээр үзсэн зохиолоос нэгийг сонгон, өөрт төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ 50-60 үгэнд багтаан бичээрэй. / 5 оноо /

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....


7. "Цагаан дар эх" туужийн хэсгийг уншаад, хам сэдвийг тодорхойлж, яагаад болохыг тайлбарлаарай. /2 оноо/

Гау нэрт баян Үнэнийг өгүүлэгч хүүдээ "Орчлонгийн явдал зүүд гилбэлгээн мэт. Төрөх, өвдөх, өтлөх, үхэх энэ дөрвөн далайг яахан гэглэх бид. Эдүгээ миний олсон эд агуурс, хүн, мал, гэр балгас эцэст барагдмуй.

8. О.Бальзак "Эцэг Горио" туужийн дараах хэсэглэлд буй уран дүрслэлийг олж тайлбарлаарай. / 2 оноо /

"... Эжен нас барах гэж байгаа өвгөний дэргэд очоод түшиж байхад нь Бьяншон цамцыг нь тайлах гэсэнд өвгөн их өвчинд нэрвэгдсэн адгуус амьтан ёолж ёхолсон дуу гаргаж байгаа юм шиг тун гаслантай үл мэдэгдэх авиа гаргаж, цээжин дээрээ нэг юм тогтоож ядсан маягаар хөдөлсөнд..."


9. Үндэсний бичгээс кирилл бичигт буулган бичээрэй. Үгийн тоо-25 /5 оноо /



.....
.....
.....
.....

10. Төрсөн нутгийнхаа онцлог, байгалийн үзэсгэлэн, хүн ардын зан заншлыг бахдан биширсэн агуулга бүхий аян замын тэмдэглэлийг 150-180 үгэнд багтаан бичээрэй. /10 оноо /

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

БОЛОВСРУУЛСАН: СУРГАЛТЫН МЕНЕЖЕР  Д.БАЙГАЛМАА



ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 12 ДАГААР СУРГУУЛИЙН
11 ДҮГЭЭР АНГИЙН СУРАГЧДААС АВАХ МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН
МАТЕРИАЛ

2024.06.06

Хугацаа 80 минут

В хувилбар

Хэрлэн сум

Нийт оноо: 40

Анги:

Сурагчийн нэр:

Эхийг анхааралтай уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.

Нутаг ус минь

Хаг нуураас чанагш баруун өмнө зүгийг барин явахад модтой уулс шувтарч нүцгэн хөх уулс угтах үес Яруу сумын Зүйл багийн төв хэмээх ганцхан гэр байв. Яг энд тавин хэдэн жилийн өмнө 1949-1950 онд Чандмань Өлзийт сумын төв хэмээх Завхан аймагтаа томоохон суурин байв.

Хоёр бага сургуультай, бага эмчийн салбар, хоршоо дэлгүүр, юм юмтай сумынхаа төвийг өнгөлж байдаг аймгийн дунд сургуулийн долдугаар анги төгссөн нутгийн егөөтэй дэгээтэй хөгшчүүдийн шог зангийн бай болсон 15-16 насны цөм дор бүрнээ хочтой золигийн арваад дэггүй банди багш байж билээ. Түүний нэг нь би байв аа. Тэр үед би салхин дүүгүүр хочтой, Найдан маань хужирхай, Содномдаржаа маань сөөсгөр, Сайжаа маань арзгар, Цэгмэд хэмээх багш охин чимээгүй гайхал гэх мэт хоч нэртэй байсан санагдана. Өдгөө энэхүү нэр хоч ор тас мартагдсан лугаа адил бага сургуулийн маань шургааган хашаа, хэдэн шавар дагз цөм газрын хөрснөөс арчигдан Зүйлийн голын хөрсөн дээр ул мөр ч үлдсэнгүй. Цаг цагаараа, цахилдаг хөхөөрөө гэдэг энэ ажгуу. Зүйл багийн дарга идэрхэн эртэй уулзвас мотоциклиор хээрийн салхи зүсэн давхисаар нүүр царай нь нар салхинд онгож хүрэн бор болсон тэрбээр хүн зонхогоо тухай бас ч гайгүй мэдээ дуулгаж байна. Тус баг 130-аад өрхтэй, 450-иад ам бүлтэй, өвгөд хөгшдийнхөө уугуул суугуул нутаг усыг дориун сахиж мал сүргээ өсгөн амьжиргаатай байгаа гэнээ. Ойрын хэдэн жил өнтэй сайхан байсан учир нэн ядуу айлгүй болсон бололтой. Үүнийгээ хангай дэлхийн хишиг л гэж ярьж сууна. Гэтэл одоо багийн дарга гэрээсээ Монгол Улсын сумдын бүх багтай богино долгионы станцаар ярьдаг болжээ. Нэгэн жарны хугацаанд Монголын хөдөө нутаг ийнхүү хол алхсан байна.

Зүйл багаас өмнө зүг өвгөд хөгшдийг минь нутаглуулсан налайсан бараан уулс, тэдний завсрын уудам талбиухан хөндий хоолой, намхан бор толгод, эгц цавчим цохио хад үргэлжилсээр нүдний хараа цуцам алсад Алтайн мөнх цаст оргилууд цайран хөхрөх тэрхүү холхид хайрлавч үл мөнхрөх амь бие, ханилавч ч үл дуусах хан хорвоо, үхэвч үл шингэрэх хүр их ертөнц, үзэвч үл ажаарах алиа орчлонгийн жамаар насан өөд болсон нутгийн маань судар ном мэт хөгшчүүд амьд мэнд байгаа мэт санагдах нь юусан билээ. Энэхэн үес Хүрэн хөндий хэмээх хүн амьтангүй ээрэм эзгүй талд машинаасаа буумагц эргэн тойрон эл хуль, нүдэнд торох өчүүхэн зүйлгүй цайран цайх газар дэлхий дэндүү уйтай гунигтай байвч яагаад ч юм бэ сэтгэлд нэг л дотно. Миний багад энэ тал өдийд чухамхүү хүрээнтэн найгаж байдаг нутаг байлаа. Анир чимээгүйхэн дүнсийх энэ нутаг цөм нэр устай, бас эзэнтэй, өвгөд дээдсээс аваад эдүгээ хүртэл энд эзэн хүн нь төрж, өсөж өндийн, зовлон жаргалаа туулсаар хээрийн салхи илбэсэн энэ хээр талын газар шороондоо шингэсэн байх бөлгөө. Би хүртэл жалга толгодын нэгэн бууцнаа 75 жилийн тэртээ эхээс мэндлэхдээ бүлээн хуурай бууцны хонины хөх хорголын дунд унасан байдаг юм. Тиймийн учир эзгүй мэт хээр талын уул хад, гүвээ толгод, жалга судаагийн нэр хүртэл ямар ч үед надад уянгатай, учиртай санагдаад байдаг юм. ...

Хангай, Алтайн завсрын энэхүү уудам нутгийн уул толгод, гуу жалга, хад цохионд Яруу сумын хоёр багийн 200 гаруй айлын 100 гаруй мянган мал жил жилд өвөлжин онд мэнд ордог гэж бодохоор ямар баян тансаг, барагдашгүй нууц эрдэнийг агуулсан газар нутаг болох нь тодоос тод ажгуу. Өвөл хаврын цас их унасан хариг хатуу цагт тэмээн сүрэг нь харганы толгой шүүрэн шүүрсээр ширээ хэвээрээ ордог бол хонь ямаан сүрэг нь туурай нь мултраагүй л бол хөр цас цавчиж хошуугаараа ярах зэргээр өвсний хэдэн бут цасан дороос гаргахад л өдрийн өл элбэг залгана. Үхэр нь хошуугаараа хэдхэн алхам газар цас онгилсоор тарган тавтай орохыг нь яана. Адуун сүрэг нь үүдэн хоймрын чинээ газар цас цавчаад л өл залгачихна. Тиймийн учир газар нутгаа арван хуруу шигээ мэддэг, туйлын сонин мэдрэмжтэй хашир догь малчид зудтай жил дов толгод, гуу судааг бүрийг өдөр өдрөөр, цаг цагаар нэгжих мэт малаа бэлчээрлүүлэн хариулсаар өнчин ишигний гарзгүй цагийн хатууг давдаг байлаа, хөөрхий. Эндхийн газар нутаг, хүн зон, мал сүрэг нь уруул шүд мэт зохицон зохицсоор олон зууныг өнгөрөөжээ. Энэ газар нутаг үе үеийн судар ном мэт хөгшдийг үдэж, тэнгэрлэг үр садаа хүлээн авч хөх бууцандаа өнхрүүлэн, элсэн хөрсөндөө хөлд оруулж, бут сөөгөндөө бүдчүүлсээр жигүүр ургуулан даль жигүүртэн нисэн үл хүрэх газар ниссэн үдэгсдийн нэгэн нь би бөлгөө...

/Зохиолч Ш.Ванчаарай/

1. "Энэ нутаг анир чимээгүй дүнсийнэ. Эзэн хүн нь зовлон жаргалаа туулсаар байна." гэсэн энгийн өгүүлбэрийг нийлмэл өгүүлбэр болгож, өгүүлбэрийн бүтэц, хэв шинжийг тодорхойлж, холбогдсон аргыг тайлбарлаарай. / 4 оноо /

Нийлмэл өгүүлбэр:

Нийлмэл өгүүлбэрийн бүтэц, хэв шинж:

Холбогдсон арга нь:

2. Дээрх эхээс мэдрэмж, сэтгэгдэл илэрхийлсэн үг хэллэг нэг, таамагласан утгатай баймж үг нэгийг тус тус олж бичээд, утга ойролцоо үг, хэллэгээр солин найруулж бичээрэй. / 4 оноо /
Мэдрэмж, сэтгэгдэл илэрхийлсэн үг хэллэг:

Солон найруулсан нь:

Таамагласан утгатай баймж үг:

Солон найруулсан нь:

3. А "Бага сургуулийн маань шургаагаан хашаа, хэдэн шавар дагз цөм газрын хөрснөөс арчигдан Зүйлийн голын хөрсөн дээр ул мөр ч үлдсэнгүй" өгүүлбэрт буй тодруулсан бүтээврийн утга, үүргийг зөв тодорхойлж бичээрэй. / 2 оноо /

голын

хөрснөөс

Б. ... газрын хөрснөөс арчигдан Зүйлийн голын хөрсөн дээр ул мөр ч үлдсэнгүй" тодруулсан бүтээврийг ойролцоо утгатай бүтээврээр солин найруулж бичээрэй. / 2 оноо /

Солон найруулсан нь:

4. Дараах үгийг холбож бичээд, зөв бичих дүрмийг тайлбарлаарай. / 2 оноо /

залгичих+ я, е, ё =

Дүрэм нь:

5. "урилга" хэмээх үгийн зөв бичих дүрмийг тайлбарлаад, уг дүрэмд холбогдох үг нэгийг бичээрэй. / 2 оноо /

Дүрэм:

Жишээ үг:

6. Уран зохиолын хичээлээр үзсэн зохиолоос нэгийг сонгон, өөрт төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ 50-60 үгэнд багтаан бичээрэй. / 5 оноо /

7. А.П.Чехов "Хамелеон" өгүүллэгийн хэсгийг уншаад, хам сэдвийг тодорхойлж, яагаад болохыг тайлбарлаарай. /2 оноо/

Хрюкин: Хялар гайхал, чи битгий худал хэл. Харсангүй байж юунд худал хэлнэ вэ? Эрхэм түшмэл ухаантай хүн тул хэн нэгэн худал хэлж байгааг, хэн тэнгэрийн өмнө шударгаар үнэн хэлж байгааг мэднэ. Хэрэв би худал хэлсэн бол даруй шүүхэд аваачиж таслуул. Хууль дүрэм гэж байна. Одоо бүгд адил эрхтэй, миний ах цагдан хянах ажилтай. Хэрэв мэдье гэвэл ...

.....

8. О.Бальзак "Эцэг Горио" туужийн дараах хэсэглэлд буй уран дүрслэлийг олж тайлбарлаарай. / 2 оноо /

"... Эжен нас барах гэж байгаа өвгөний дэргэд очоод түшиж байхад нь Бьяншон цамцыг нь тайлах гэсэнд өвгөн их өвчинд нэрвэгдсэн адеуус амьтан ёолж ёхолсон дуу гаргаж байгаа юм шиг тун гаслантай үл мэдэгдэх авиа гаргаж, цээжин дээрээ нэг юм тогтоож ядсан маягаар хөдөлсөнд..."

.....

9. Үндэсний бичгээс кирилл бичигт буулган бичээрэй. Үгийн тоо-25 /5 оноо /

1. Өмнөд урварт
 2. Төвд
 3. Баруунд
 4. Зүүнд
 5. Өмнөд урварт
 6. Төвд
 7. Баруунд
 8. Зүүнд
 9. Өмнөд урварт
 10. Төвд
 11. Баруунд
 12. Зүүнд

.....

10. Өөрийн аялсан газар орны онцлог, байгалийн үзэсгэлэн, хүн ардын зан заншлыг бахдан биширсэн агуулга бүхий аян замын тэмдэглэлийг 150-180 үгэнд багтаан бичээрэй. /10 оноо /

.....

